

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/172/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Нурлан
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ХӨХ СЭРХИЙН НУРУУНЫ УЛСЫН
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Х.САНДИГҮЛ ТАНАА

додд.од.15 № 54
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Холбооны бүгд найрамдах Герман улсын олон улсын хамтын ажиллагааны GIZ /Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох/ төслийн шугамаар хүлээн авч ашиглаж байгаа Ланд-79 маркын авто машиныг холбогдох байгууллагуудаас төрийн өмчид бүртгэх талаар шийдвэр гараагүй байгаа учраас данс бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

1. Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17312101.64</u>	<u>32070987.72</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	17312101.64	32070987.72
354	Хангамжийн материал	17312101.64	32070987.72
35410	Бичиг хэргийн материал	1816477.44	1758323.52
35420	Аж ахуйн материал	12802164.20	26010664.20
35440	Түлш, шатах тослох материал	923460.00	800000.00
35470	Бусад хангамжийн материал	1770000.00	3502000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>158393327.89</u>	<u>160187344.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	158393327.89	160187344.49
392	Биет хөрөнгө	150393327.89	152187344.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	87380260.00	92380260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9737724.08	-13486507.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44797500.00	44797500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9060138.98	-15825972.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54770288.47	68853033.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32818003.07	-40394875.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10969507.43	10969507.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6837503.93	-7018101.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	12423264.34	13623264.34
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1494122.29	-1710764.34
393	Биет бус хөрөнгө	8000000.00	8000000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8000000.00	8000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>175705429.53</u>	<u>192258332.21</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>175705429.53</u>	<u>192258332.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	175705429.53	192258332.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	119412541.75	119412541.75
51101	Өмч: - төрийн	119412541.75	119412541.75
512	Хуримтлагдсан үр дүн	34234569.53	50787472.21
51210	Өмнөх үеийн үр дүн	34234569.53	34234569.53
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	16552902.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22058318.25	22058318.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>175705429.53</u>	<u>192258332.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	215,010,800.00	273,800,195.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,373,800.00	55,164,495.46
120	Нийтлэг татварын бус орлого	1,373,800.00	55,164,495.46
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,373,800.00	55,164,495.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,373,800.00	1,219,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	53,945,495.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	213,637,000.00	218,635,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	212,637,000.00	216,635,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,637,000.00	216,635,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	2,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	239,506,380.25	257,247,292.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	239,506,380.25	257,247,292.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,464,187.85	253,988,343.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	123,600,280.10	156,423,807.18
210101	Үндсэн цалин	120,037,243.10	148,468,674.18
210102	Нэмэгдэл	3,563,037.00	7,955,133.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,532,656.50	19,917,994.48
210201	Тэтгэврийн даатгал	11,583,145.38	13,661,831.48
210202	Тэтгэмжийн даатгал	1,237,378.53	1,564,040.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	989,900.62	1,251,233.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,473.91	312,810.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,474,758.06	3,128,080.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,052,190.00	2,417,313.03
210301	Гэрэл, цахилгаан	364,190.00	247,175.00
210302	Түлш, халаалт	2,558,000.00	2,077,278.03
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	92,860.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,025,297.50	23,261,854.89
210401	Бичиг хэрэг	1,444,339.50	2,070,053.92
210402	Тээвэр, шатахуун	13,719,858.00	17,113,150.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,112,000.00	1,105,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,131,000.00	100,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,618,100.00	2,873,150.00
2105	Нормативт зардал	-	20,128,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	20,128,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,887,200.00	4,545,557.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	316,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	10,571,200.00	4,345,557.00

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	2,693,050.00	1,494,000.00
210702	Дотоод албан томилолт	2,693,050.00	1,494,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,004,021.00	7,258,338.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,423,783.00	6,962,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	175,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	101,738.00	99,888.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,700.00	32,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	12,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	151,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,669,492.75	18,540,728.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	421,500.00	52,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,247,992.75	18,488,728.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,042,192.40	3,258,949.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,042,192.40	3,258,949.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,042,192.40	3,258,949.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(24,495,580.25)	16,552,902.68
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(24,495,580.25)	16,552,902.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	215010800.00	219854700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1373800.00	1219000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1373800.00	1219000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1373800.00	1219000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1373800.00	1219000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	213637000.00	218635700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	212637000.00	216635700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212637000.00	216635700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1000000.00	2000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1000000.00	2000000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	213613600.00	218654700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213613600.00	218654700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212571407.60	215395750.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	123733831.00	155201994.78
210101	Үндсэн цалин	89553200.00	118389194.78

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	31214200.00	33725500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2966431.00	3087300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16532654.60	19918006.88
210201	Тэтгэврийн даатгал	11583141.28	13545200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1237378.33	1593068.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	989902.70	1274434.44
210204	Ажилгүйдлийн даатгал	247475.63	318633.59
210205	Эрүүл мэндийн даатгал	2474756.66	3186670.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3878290.00	2957335.00
210301	Гэрэл, цахилгаан	453190.00	268975.00
210302	Түлш, халаалт	3241700.00	2595500.00
210303	Цэвэр, бохир ус	183400.00	92860.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13792810.00	12381800.00
210401	Бичиг хэрэг	296900.00	368700.00
210402	Тээвэр, шатахуун	11958910.00	10781800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1386000.00	1105500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	151000.00	125800.00
2105	Нормативт зардал	198000.00	166000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	198000.00	166000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	242300.00	5199200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	242300.00	200000.00
210602	Тавилга		4999200.00
2107	Томилолт, зочны зардал	2693050.00	1494000.00
210702	Дотоод албан томилолт	2693050.00	1494000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51395372.00	17992414.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50815134.00	17646476.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	175000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	101738.00	99888.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38700.00	32400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14800.00	12400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250000.00	201250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105100.00	85000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105100.00	85000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1042192.40	3258949.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1042192.40	3258949.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1042192.40	3258949.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1397200.00</u>	<u>1200000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1397200.00	1200000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1397200.00	1200000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1397200.00	1200000.00

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1397200.00	1200000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1397200.00	-1200000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,412,541.75	22,058,318.25	34,234,569.53	175,705,429.53
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	119,412,541.75	22,058,318.25	34,234,569.53	175,705,429.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	119,412,541.75	22,058,318.25	34,234,569.53	175,705,429.53
D08	Тайлант үеийн үр дүн			16,552,902.68	16,552,902.68
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,412,541.75	22,058,318.25	50,787,472.21	192,258,332.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,785,700.00	214,601,350.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,785,700.00	214,601,350.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,785,700.00	214,601,350.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,354,700.00	156,401,994.78
210101	Үндсэн цалин	122,541,900.00	119,589,194.78
210102	Нэмэгдэл	33,725,500.00	33,725,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,087,300.00	3,087,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,919,300.00	19,918,006.88
210201	Тэтгэврийн даатгал	13,545,200.00	13,545,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,593,500.00	1,593,068.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,274,800.00	1,274,434.44

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	318,700.00	318,633.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,187,100.00	3,186,670.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,115,400.00	2,957,335.00
210301	Гэрэл, цахилгаан	366,000.00	268,975.00
210302	Түлш, халаалт	2,602,100.00	2,595,500.00
210303	Цэвэр, бохир ус	147,300.00	92,860.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,208,000.00	11,199,400.00
210401	Бичиг хэрэг	368,700.00	368,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,599,400.00	9,599,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,112,500.00	1,105,500.00
210404	Ном, хэвлэл	127,400.00	125,800.00
2105	Нормативт зардал	166,400.00	166,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	166,400.00	166,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,203,600.00	5,199,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	203,600.00	200,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,999,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,085,100.00	1,085,000.00
210702	Дотоод албан томилолт	1,085,100.00	1,085,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,644,600.00	17,589,414.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,289,800.00	17,243,476.00
210803	Даатгалын үйлчилгээ	99,900.00	99,888.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,400.00	32,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,400.00	12,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,100.00	201,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,600.00	85,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	88,600.00	85,000.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,785,700.00	214,601,350.66
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	216,635,700.00	213,451,350.66
131001	Улсын төсвөөс санхүүжих	216,635,700.00	213,451,350.66
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,150,000.00	1,150,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,050,000.00	1,150,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15.00	15.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00
--------	--	------	------

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, эко системийн унаган төрхөөр нь экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр хадгалж, нутгийн иргэдийн оролцоотойгоор биологийн олон янз байдлыг хадгалах чиг үүргийг хэрэгжүүлэн байгаль орчноо хамгаалах зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан 2 зорилт арга хэмжээний хүрээнд 20 арга хэмжээг дэвшүүлж ажилласан байна. Тус зорилтын хүрээнд:

- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт арга хэмжээ

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны дарга Х.Сандигүлийн 2022 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин Байгаль орчин аялал жуулчлалын сайд 93.1 хувиар үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь Байгаль орчныг хамгаалах багц хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/641 тоот тушаалаар баталсан НББ-ийн бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгосон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.5 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	17,312.1	32,070.9	14,758.8
Үндсэн хөрөнгө	158,393.3	160,187.3	1,794.0
Нийт хөрөнгө	175,705.4	192,258.3	16,552.9
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	175,705.4	192,258.3	16,552.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	175,705.4	192,258.3	16,552.9

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын хөрөнгө 14,758.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас GIZ төслөөр үнэгүй хөрөнгө авсантай холбоотой байна.

Бараа материалын данс 1.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 29.9 сая төгрөгийн материал худалдан авч, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас үнэгүй 33.1 сая төгрөгийн дүрэмт хувцас, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 1.7 сая төгрөгийн бусад хангамжийн материал авч, үйл ажиллагаанд 50.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 1.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 2 ширхэг Эко жорлонг 1.2 сая төгрөгөөр худалдан авч, Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас GIZ

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

төслөөр 14.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 5.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 машины гражийг үнэгүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 18.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 16.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсөв болон орон нутгийн төсвөөс 788.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 788.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 256.9 сая төгрөгийн, үйл ажиллагааны орлогоос 1.1 сая төгрөгийн, нийт зарлагыг 258.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.3 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 13.3 сая төгрөгөөр, норматив зардлыг 0.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.2 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 3.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 45.5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 0.9 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 0.7 сая төгрөгөөр бууруулж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 29,4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 38.7 сая төгрөгөөр бууруулж, 217.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 38.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 217.8 сая төгрөгийг улсын төсөв болон үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 216.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 214.6 сая төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3.2 сая төгрөгөөр дутуу зарцуулж жилийн эцэст 3.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	200,495.9	197,357.9	3,138.0	98.4%
2	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	8,730.3	8,711.5	18.8	99.8%
3	Ургамал хамгаалал	8,559.5	8,531.9	27.6	99.7%
	Дүн	217,785.70	214,601.30	-3,184.40	98.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 онд 2.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 239.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2.9 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал нийтдээ 0.2 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг зөрчиж 1.1 сая төгрөгийн шагнал олгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 37%, хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 63% байна. Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14.3 сая төгрөгийн 8 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүнгээр шилэн дансны зөрлийг арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг улирал бүр хийж байжээ. Хэрэгжилтийг яамны хэмжээнд “Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа” тус бүр хавсралтаар гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	2,100.1		0	0%
Нийт дүн	1	2,100.1		0	0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Германы Олон улсын хамтын ажиллагааны GIZ төслийн шугамаар 2022 оны 08 дугаар сард Ланд-79 маркын авто машиныг хүлээн авч ашиглаж байгаа боловч Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчид бүртгэх талаар зохих шийдвэргүй гараагүй байгаа учраас үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгахгүй байх чиглэл өгсний дагуу орлогод аваагүй байгаа асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад төсвийн гүйцэтгэлийн тайланд 3.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн цалингийн зардлын 3.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлын 0.04 сая төгрөгөөр, улсын төсвөөс санхүүжих дүнг 0.069 сая төгрөгөөр нийт 3.5 сая төгрөгөөр алдаатай илэрхийлснийг залруулав.

Аудитаар нийт 22.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 22.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

5.2 Албан шаардлага

1. Бичиг хэргийн материалын зардал, дотод албан томилолтын зардал, судалгааны мөнгөн зарлага, сургалтын материалын зардал, замын зардал, программ, сургалтын төлбөрийн зардлуудын нийт 7.2 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөх сэрхийн нурууны Улсын тусгай Хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 14.3 сая төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 37 хувьтай байгаа зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

3. Байгууллагын даргын А/19 тоот тушаалаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/362 тоот тушаал гарснаар хүчингүй болсон 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/159 тоот тушаалыг үндэслэн "Хоггүй цэвэр айл" аяныг зохион явуулж, 4 иргэнийг шагнаж төсвийн хууль тогтоомжийг зөрчиж 1,100.0 мянган төгрөгийг төсвөөс гаргасан байна.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн Төсвийн Гүйцэтгэлийн тайлангийн зарим зардлуудад	1	3,506.7					1	3,506.7				
Дүн	1	3,506.7					1	3,506.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	7,240.8			1	7,240.8						
Дүн	1	7,240.8			1	7,240.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 8 шийдвэрийг гарсны, мэдээлээгүй байна	1	14,340.8			1	14,340.8		
Дүн	1	14,340.8			1	14,340.8		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-д заасныг зөрчиж 1.1 сая төгрөгийн шагнал олгосон.	1	1,100.0			1	1,100.0		
Дүн	1	1,100.0						
Нийт дүн	2	15440.8			1	15,440.8		